



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/452

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цаашдын үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор 2017 оны 7 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд айлчлах БНСУ-ын Тэжон хотын Согу дүүргийн төлөөлөгчдийг хүлээн авах зардлыг 5.600.000 /Таван сая зургаан зуун мянган/ төгрөгөөр тогтоосугай.

2. Дээрх зардлыг "Засаг дарга" данснаас зарцуулахыг аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч /Ц.Мөнхтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД